

## МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ

### БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХҮСНЭГТ

Баримт бичгийн нэр		Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам		
Баримт бичгийн дугаар		НС-Ж-08-09/1.0		
Баримт бичгийн нууцлалын зэрэг		Нууц		
	<b>Боловсруулсан</b>	<b>Албан тушаал</b>	<b>Гарын үсэг</b>	<b>Огноо</b>
1	Б.Эрдэнэсүх	СБГ-ын Ахлах Санхүүгийн шинжээч		2022/12/13
	<b>Хянасан</b>	<b>Албан тушаал</b>	<b>Гарын үсэг</b>	<b>Огноо</b>
1	С.Сугардалай	Хуульч	хянасан	2022/12/15
2	Э.Золбоо	ГУГ-ын захирал	хянасан	2023/01/10
3	С.Бурмаа	ЭУГ-ын захирал	хянасан	2023/01/19
4	Т.Жавхлан	ТУЗ-ийн хараат бус гишүүн	хянасан	2023/01/13
5	С.Оргодол	ТУЗ-ийн хараат бус гишүүн	хянасан	2023/01/13
6	Б.Болорчимэг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	хянасан	2023/01/13
7	Л.Оргил	ТУЗ-ийн хараат бус гишүүн	хянасан	2023/01/13
8	А.Урангоо	ТУЗ-ийн хараат бус гишүүн	хянасан	2023/01/13
9	Б.Мөнхжавхаа	ТУЗ-ийн хараат бус гишүүн	хянасан	2023/01/13
	<b>Баталсан</b>	<b>Албан тушаал</b>	<b>Гарын үсэг</b>	<b>Огноо</b>
1	Д.Алтангэрэл	ТУЗ-ийн дарга		
Баримт бичгийн батлагдсан огноо		2023 оны 01 сарын 17-ны өдөр		
Баримт бичгийн хариуцагч		Санхүү бүртгэлийн газар		
Хувилбар		01		

### ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Хувилбар дугаар	Өөрчлөлт оруулсан бүлэг	Өөрчлөлтийн товч утга	Шинэчилсэн албан тушаалтан	Огноо
01	-	Анхны хувилбар	Б.Эрдэнэсүх	2023/12/13

### ЦАХИМ ХАДГАЛАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

Баримт бичгийн хадгалагдаж фолдерын нэр	Цахимаар баримт бичиг хадгалагдаж буй газрын линк

## АГУУЛГА

<b>НЭГ. ЖУРМЫН ЗОРИЛГО</b>	<b>2</b>
<b>ХОЁР. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ИЛ ТОД БАЙДАЛ</b>	<b>3</b>
<b>ГУРАВ. ЖИЛИЙН ТАЙЛАН</b>	<b>3</b>
<b>ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ</b>	<b>4</b>
<b>ТАВ. САНХҮҮГИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТИЙН ИЛ ТОД БАЙДАЛ</b>	<b>4</b>
<b>ЗУРГАА. ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ</b>	<b>4</b>
<b>ДОЛОО. ХАРИУЦЛАГА</b>	<b>4</b>
<b>ХАВСРАЛТ 1. ЖИЛИЙН ТАЙЛАНД САНХҮҮГИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТИЙН</b>	<b>5</b>
<b>МЭДЭЭЛЭЛ ТУСГАХ ЗАГВАР</b>	<b>5</b>

### НЭГ. ЖУРМЫН ЗОРИЛГО

- 1.1 Нэткапитал Финанс Корпораци ББСБ ХХК /цаашид Групп гэх/-ийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмын зорилго нь төрийн эрх бүхий байгууллага болон олон нийтэд үйл ажиллагааг мэдээллэх, мэдээлэл хэрэглэгчдийг цаг тухай бүр үнэн зөв санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллээр хангах харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү журам нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон компанийн засаглалын кодексийн хүрээнд нийцсэн байна.

### ХОЁР. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

- 2.1. Эрх бүхий албан тушаалтан гэж Компанийн тухай хууль болон Группийн дүрэмд заасны дагуу тодорхойлсон албан тушаалтныг тооцно.
- 2.2. Эрх бүхий албан тушаалтны мэдээлэл өөрчлөгдсөн албан шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан мэдээллийг шинэчилж, олон нийтэд мэдээлнэ.
- 2.3. Эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой дараах зүйлсийг нийтэд мэдээлнэ. Үүнд:
  - 2.3.1. ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, ажиллах зарчим гишүүдийн хараат бус байдлыг тодорхойлох шалгуур үзүүлэлт
  - 2.3.2. ТУЗ-ийн гишүүдийн нэр, мэргэжлийн ур чадвар, ажлын дадлага туршлага
  - 2.3.3. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн, үйл ажиллагаа, эрх үүрэг, тайлагналын тогтолцооны талаар
  - 2.3.4. Эрх бүхий албан тушаалтны албан тушаал, нэр, ажлын туршлага

### ГУРАВ. ЖИЛИЙН ТАЙЛАН

- 3.1. Жилийн тайлан гэдэгт Группийн үйл ажиллагааны жилийн тайланг ойлгоно.
- 3.2. Жилийн тайланг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гүйцэтгэх захирлаар батлуулна.
- 3.3. Жилийн тайлан дараах агуулгатай байна. Үүнд:
  - 3.4.1. Группийн товч танилцуулга
  - 3.4.2. Харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг, харилцагчдын эрх ашгийг хамгаалах талаар баримтлах бодлогын хэрэгжилт
  - 3.4.3. Удирдлагын ёс зүйн талаар баримтлах бодлого болон зохистой засаглалын зарчмын хэрэгжилт
  - 3.4.4. Бизнесийн үйл ажиллагааны онцлох үзүүлэлтийн өөрчлөлт, тайлбар
  - 3.4.5. Санхүүгийн голлох үзүүлэлтүүд, өөрчлөлт, тайлбар
  - 3.4.6. Дотоод аудитын тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг
  - 3.4.7. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны тайлан
  - 3.4.8. Хүний нөөцийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт
  - 3.4.9. Салбар нэгжийн тоо, байршил, үйл ажиллагааны талаарх мэдээлэл
  - 3.4.10. Группийн нийгмийн хариуцлага, тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийн хэрэгжилт
  - 3.4.11. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн үнийн дүн, тоон үзүүлэлтийн тайлан болон холбогдох тайлбар.

#### **ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ**

- 4.1. Групп нь үйл ажиллагаатай холбоотой дараах мэдээллийг цахим хуудсандаа байршуулж, олон нийтэд мэдээлнэ. Үүнд:
- 4.1.1. Группийн удирдлагын зохион байгуулалтын бүтэц, эрх зүйн хэлбэр, байршил
  - 4.1.2. Группийн эрхлэх үйл ажиллагааны чиглэл
  - 4.1.3. Группийн тусгай зөвшөөрлийн мэдээлэл
  - 4.1.4. Жилийн үйл ажиллагааны тайлан
  - 4.1.5. Салбар нэгжийн тоо, байршил
  - 4.1.6. Группийн бүтээгдэхүүн үйлчилгээний ерөнхий нөхцөл, хүү, шимтгэл, хураамжийн мэдээлэл
  - 4.1.7. Бусад шаардлагатай мэдээллүүд
- 4.2. Журмын 4.1-д тусгагдсан мэдээллийг өөрчлөх шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор шинэчилнэ.

#### **ТАВ. САНХҮҮГИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТИЙН ИЛ ТОД БАЙДАЛ**

- 5.1. Групп нь тухайн жилийн санхүүгийн тоон үзүүлэлтийг Хавсралт №1-т оруулсан загварын дагуу гаргаж, жилийн тайланд оруулж олон нийтэд мэдээлнэ.

#### **ЗУРГАА. ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ**

- 6.1. Групп нь жилийн тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор группийн цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлнэ.

#### **ДОЛОО. ХАРИУЦЛАГА**

- 7.1. Энэ журмаар хүлээсэн үүргийг биелүүлээгүй, тогтоосон хэм хэмжээг зөрчсөн ажилтанд Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу зөрчлийн шинж чанар, учруулсан хохирлын хэмжээг харгалзан сахилгын шийтгэл ногдуулна.
- 7.2. Энэхүү журмын хэрэгжилтэд Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх захирлын орлогч нар, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар хяналт тавина.

**ХАВСРАЛТ 1. ЖИЛИЙН ТАЙЛАНД САНХҮҮГИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТИЙН  
МЭДЭЭЛЭЛ ТУСГАХ ЗАГВАР**

Үзүүлэлт	Хугацааны эхний үлдэгдэл	Хугацааны эцсийн үлдэгдэл
НИЙТ ХӨРӨНГӨ		
НИЙТ ЭХ ҮҮСВЭР		
НИЙТ ЗЭЭЛИЙН БАГЦ		
ЦЭВЭР АШИГ		